



Сэтгэлийн үхэшгүйд итгэх нь үнэн итгэлд хор нөлөөтэй

Ариун бичвэрүүдийн дагуу Бүтээгч Эзэнтэй хамт алхдаг байсан хүмүүс нас барсныхаа хойно Түүнийг магтдаггүй, санадаг ч үгүй, ер нь юу ч мэдэхгүй, бас мэдрэхгүй. Хүн бол махбод, амин сүнс хоёроор бүрдсэн “амьд сэтгэл” бөгөөд махбод, амин сүнс хоёр үхлээр салахад юм мэдэрдэг, сэхдэг сэтгэл нь үгүй болдог учраас тэр. Амсыгаа хураасан хүн “Үхэгсдийн орон”-д буюу булшинд нойрсох мэт хэвтнэ. Хүн бүр үхээд байдаг шалтгаан нь өвөг эцэг Адамаас өвлөж авсан “төрөлхийн үхэл” юм. Харин сайхан мэдээ нь болохоор үхэл бүх юмны эцэс биш. Биднийг гэм ба үхлээс аврах Аврагч Эзэн бий. Есүс Христ загалмай дээр гэм ба үхлийн асуудлыг нэгмөсөн шийдвэрлэсэн. Энэ бүхнийг бид өмнөх хэдэн нийтлэл дээрээс олж харсан.

Гэвч хэцүү юм нь, хүний сэтгэл үхэшгүй мөнх байдаг гэж бид багаасаа сонссон. Монголчууд лав үхэгсдийг “өөд болсон”, “бурхан болсон” гэж ярьдаг. Бас нас барсан хүний сэтгэл шинэ бие махбодод шилжин орж, хойд амьдралтай болдог гэж олон хүн боддог.¹

1 Сэтгэл, сүнс хоёрыг сайн ялгадаггүй бол мөн “сүнсний үхэшгүй байдал” гэж ярина. Библийн дагуу сүнс нь хүнийг амьдруулах амь учраас мэдээж үхэхгүй, Бүтээгч Эзэндээ буцдаг (Номлогчийн үгс 12:7). Гэтэл биегүй сүнс амь нь болохоос тэр хүн өөрөө биш. Хүний сүнс бол сэтгэж мэдэрдэг оршнол биш болохыг ойлгох нь чухал. Таны сүнс чинь та өөрөө биш. Амин сүнс бие махбодтой нэгдсэний үр дүнд хүний сэтгэж мэдрэх чадвар бий болдог. Үүнийг Бичвэрд “сэтгэл” гэж нэрлэдэг. Шашин тэр л чадварыг бие махбодгүйгээр оршиж чадах, үхэшгүй оршнол гэж заадаг нь буруу.



Сэтгэлийн үхэшгүйд итгэхийн хор нөлөө □ 2

Харин Есүст итгэдэг хүмүүс бидэнд “*итгээгч хүн нас барахдаа шууд л мөнхийн улсад явж Есүстэй уулзана*” гэж заалгасан. Гэвч энэ нь Бичвэрүүдийн сургаалтай нийцэхгүй нь тодорхой.



Тэгвэл хүний сэтгэл мөхөшгүй гэсэн ойлголт хаанаас үүсэн, Христитгэлд хэрхэн орсон юм бэ? Ийм ойлголттой явдагаас болж Библийн үнэн сургаалыг ойлгож авахгүйн улмаас үнэмшихгүй байх нь ямар үр дагавартай вэ? гэсэн асуултын зарим хариуг энэ нийтлэлд танилцуулах болно.

Христитгэлд ихэд нөлөө үзүүлсэн эртний грек шашнаас эхэлье. Грекчүүд сэтгэлийг үхэшгүй мөнхийн зүйл, харин хүний бие махбодийг сэтгэлийг хорьдог “шорон” гэж үздэг ажээ. Үхлээр тэр шоронгоосоо чөлөөлөгдөн хальж одох сэтгэл хаа нэг газар очоод орших ёстой нь ойлгомжтой. Иймд Үхэгсдийн орон грекчүүдийн үзлээр жаргах ба тамлагдах хоёр хэсэгтэй бодит газар аж.



Агуу Александрийн зүтгэлээр грек соёл дэлхийд дэлгэрэхэд олон иудейчүүд хүртэл грек хэлтэй, грек соёлтой болсон. Грек дэлхий үзэх үзэл ч тэдэнд нөлөөлсөн гэсэн үг. Ямартай ч иудей шашны бүлэг болох фарисайчууд үхэшгүй сэтгэлийн очдог хоёр тасагтай Үхэгсдийн орны тухай грекчүүдийн “гүн ухаан”-ыг өөрийн сургаал болгосон.

Дараа нь Христийн сүм үүсч, хэдэн зуун жил болсны дараа зарим нь мөн адил Платоны гүн ухааныг

Библийн сургаалтай хольж хутгаад, сэтгэлийн үхэшгүйг Католик сүмийн теологид оруулсан нь мөн түүхийн баримт. Католик сүм Үхэгсдийн орны хоёр тасгийг тэнгэр ба там гэж нэрлэв. “Дуулгавартай хүмүүс нас барахдаа тэнгэрийн жаргалд орно, харин дуулгаваргүй муу хүмүүс тамд очиж мөнхөд тамлагдана” гэж заадаг болжээ. Протестантууд олон католик онол сургаалыг эсэргүүцсэн боловч, үхэшгүй сэтгэл нэг бол тэнгэрт, нэг бол тамд орох тухай онолыг даанч өвлөн авчээ.

Уг нь Ертөнцийн Эзэний үг еврей хэлээр сэтгэлийн үхэшгүйг дэндүү тодорхой үгээр үгүйсгэдэг. Үүний бас нэгэн жишээ: “ЭЗЭНий үг надад ирж, «...**Нүгэл үйлддэг** амь [еврей: **сэтгэл**] **үхэх болно**»” гэжээ (Езекиел 18:1,4; жич: амьтан үхэх болохоос амь өөрөө үхнэ гэж байхгүй, еврей эх нь зөв).



Үхэх сэтгэлд үхэшгүй чанар алга гэж хэлэх шаардлагагүй биз ээ. Мөн:

Үхэл бол арай өөр
байдлаар амьд
явахыг хэлээгүй
юм.
Үхэл бол амьгүй
байх байдлыг
хэлнэ.

“Ноёдод, авралгүй хүний хүүд
бүү итгэ.

Сүнс нь гарч явах үед тэд
газар шороо руу буцдаг.

Яг тэр өдөр бодлууд нь мөхдөг юм...”
(Дуулал 146:3-4; АБ)

Хүний сэтгэл нэгэнт үхээд
бодлууд нь мөхөх учраас аймшигтай газар явж,
тарчлан шанална гэж байхгүй гэсэн үг. Ганц
үлдсэн асуулт: Их Эзэний тодорхой үгэнд бид
итгэх нь зөв үү, бодол санаа нь устан үхэх
тавилантай хүнд итгэлээ өгөх ёстой юмуу?
Хариу нь итгэгч хүний хувьд тодорхой.
Сэтгэлийн үхэшгүйн тухай онолын эх үүсвэрийг
мэдэж авбал хариу нь улам ч тодорхой болно.



Үхэшгүй сэтгэлийн тухай онолын эх үүсвэр

Эхлэл 3:4-д анхаарал татам дараах үг бий: “*Та нар ерөөсөө үхэхгүй!*”

“Библид байгаа учраас энэ үг үнэн” гээд шууд
хүлээж авахаасаа өмнө энэ үгийг хэн хэлснийг

шалгах нь зүйтэй. Энэ үгийн
эзэн бол өнөөх алдарт
Могой билээ. Тус “хуучны
могой” бол “бүх ертөнцийг
мэхлэгч” адгийн муу ёрын
сүнс буюу Сатан (Илчлэлт
12:9, 20:2).





Есүс түүнийг мөн “худалч бөгөөд худал хуурмагийн эцэг” гэж нэрлэсэн билээ (Иоган 8:44).

Тодорхой нэгэн модны жимсийг идэж болохгүй, идвэл “үхэх гэж үхдэг байх болно” гэж Ертөнцийн Эзэн Адам, Ева хоёрт анхааруулсан байв². Гэтэл могой хүрч ирж, “*Та нар ерөөсөө үхэхгүй!*” гээд Ертөнцийн Эзэний үгийг шууд үгүйсгэв.

Анхны хоёр хүн даанч Ертөнцийн Эзэний Үгэнд итгэхийг зөв гэж үзээгүй. Иймд Бүтээгч Эзэндээ итгэхийн оронд муу ёрын сүнсний дээрх худалд автсан юм. Адам, Ева хоёр Их Эзэний Үгийг зөрчихдөө шууд Түүний хэлсний дагуу үхэх явцад ороод, эцэст нь үнэхээр амьсгаа хураажээ. Улмаар, тэд Бүтээгч Эзэнд үл итгэснээр бүх хойч үеийнхэндээ буюу хамаг хүн төрөлхтөнд гэм ба үхлийг авчирсан. Тэгсэн ч гэсэн ихэнх хүн Могойг мэргэн ухаантай гэж үзсэн хэвээр. Тэд үгнээс нь зууралдан, “бид махбодоороо үхсэн ч сэтгэлээрээ лав үхэхгүй, цаашид амьдарна” гээд үгийг нь бодит байдалд тааруулж өөрчиллөө.



Үр дүнд нь сэтгэлийн үхэшгүйн тухай сургаал яваандаа бүх шашинд орж, үндсэн номлол нь болжээ. Өнөөг хүртэл дэндүү олон хүн, тэр тусмаа өөрийгөө “Христэд итгэгч” гэдэг хүмүүс Их Эзэний үгэнд биш, худалч Могойн тэр үгэнд итгэсэн хэвээр байгаа нь үнэхээрийн харамсалтай.

2 Еврей эх нь тийм утгатай. АБ даанч “Түүнээс идсэн тэр өдөртөө л чи зайлшгүй үхнэ” гэж буруу ойлгогдохоор орчууллаа (Эхлэл 2:17).



Үүний гол шалтгаан нь хүний бардам зан болой. Хүн амь насаа Бүтээгч Эзэний гарт даатган үлдээхийг хүсэхгүй, юмаа өөрөө л болгоод амьдралынхаа эзэн байхаар тэмүүлнэ. Үхэхдээ амьдралаас бүрэн салж, оршихоо болино гэж бодохоор дэндүү аймаар санагдах учраас биегүй ч гэсэн дор хаяж сэтгэлээрээ амьд үлднэ гэсэн бодлоос зуурдаг. Гэвч үхэл гэдэг нь Бичвэрүүдийн дагуу “арай өөр байдлаар амьд явах”-ыг хэлээгүй, амьгүй байхыг хэлнэ.

“Үхэл юу болохыг тайлбарласан тал дээр та тэгвэл Хэнд итгэх вэ – Бүтээгч Эзэндээ юу? Могойд уу?” гэдэг асуулт танд дахин тавигдаж байна.



Үхлийг зөв ойлгоогүйн улмаас тайлагдашгүй олон асуудал гардаг

Үхлийн тухай Бүтээгч Эзэний Бичвэрүүдэд үлдээсэн тод үгийг үл ойшоосны улмаас сэтгэлийн үхэшгүй мөнх ба дагалдаас нь болох мөнхийн зовлонт тамын тухай сургаал орж ирсэн. Гэвч муу ёрын сүнсний гаргасан, хүмүүсийн уламжилж ирсэн эдгээр онол сургаалд итгэсэн Христэд итгэгч хүний хувьд өөрийн эрхгүй олон тайлагдашгүй асуудал үүснэ.

1. Юуны өмнө хэлэхэд, энэ сургаал Бүтээгч Эзэний үнэнч хайранд эргэлзэхэд хүрнэ. Хүн бүрт хайртай гэдэг боловч Өөрийг нь хүлээж аваагүй хүнийг тамд хаядаг Эзэнд хүн өөрийгөө хэрхэн даатгах вэ?



Сэтгэлийн үхэшгүйд итгэхийн хор нөлөө □ 7

Дайснаа хайрла гэж тушаадаг боловч Өөрөө дайснуудаа хайрладаггүй Эзэний үгэнд итгэлээ хэрхэн бүрэн өгөх вэ? Нэг ч хүнийг гэсэн тамлаж чадах юм бол Түүнд яаж чин сэтгэлийн хайраа зориулах вэ? Энэ сургаал ер нь Бүтээгч Эзэний үндсэн зан чанарыг эргэлзээнд оруулах нөлөөтэй юм.

2. Мөн Бүтээгч Эзэний мэргэн ухаан, хүч чадлын тал дээр эргэлзээ төрүүлнэ. Хамгаас мэргэн Эзэн ёрын мууг дарахын тулд хайрт бүтээлээ тамд хаяхаас илүү сайн



төлөвлөгөө гаргаж болохгүй байсан уу? Хүн мөнхөд зовох тамиртай болох нь мөнхийн гайхамшиггүйгээр бүтэхгүй биз ээ. Хүмүүсийг тамын галд шатааж үхүүлэхгүйгээр амьд байлгахад Их Эзэн яагаад хүч чадлаа зарцуулах ёстой вэ? Тэрний оронд хүч чадлаа, хүн болгоныг аврах хүслээ биелүүлэхэд ашиглах нь дээр биш үү? Өөрийн хувь заяаг шийдэх эрхийг Бүтээгч Эзэн хүнд өгсөн гэдэг. Тийм бол шийдвэрийнхээ ач холбогдлыг бүрэн ойлгох ойлголтыг яагаад чөлөөт хүсэл зоргийн хамт өгөөгүй юм бэ?

3. Сэтгэлийн үхэшгүйг заасан сургаал нь шударга ёсны талаар асуулт гаргадаг. Өөрийнх нь үеэс 2000 жилийн өмнө сөнөсөн Содом хотынхон ирээдүйд л шүүгдэх болно гэж Есүс хэлсэн (Матай 10:15, 11:24).



Шүүлт хараахан болоогүй ч гэсэн Содомын иргэд одоо ч тамд шатаж байгаа гэж олон итгэгч итгэдэг. Уг нь нийгмийн шударга ёсны журмын дагуу хүнийг шударгаар шүүхээс наана шийтгэж болохгүй.

“Их Эзэн бүхнийг мэддэг учраас шүүлт явуулах шаардлагагүй байж болно”

гэж тэд хэлж магад. Гэтэл ирээдүйд шүүлт явуулахаа Тэр Өөрөө нэгэнт олон хэлсэн учраас шийтгэл шүүхийн араас л гүйцэтгэгдэх ёстой.



Улмаар, шударга ёсны нэг зорилго нь өшөө авахад оршсон ч, хамгийн эрхэм зорилго нь гэмт хэрэгтэнг шийтгэх замаар ухааралд хөтлөн, зан төлөвөө сайжруулахад хүргэх явдал юм.

Бүтээгч Эзэний шударга ёсны журам, бас зорилго нь хүнийхээс ариун шударгаараа хол илүү давсан байх ёстой биш гэж үү?

4. Библийн хамгаас чухал сургаал бол үхлээс амилах амилал юм.

Христэд итгэсэн үхэгсэд одоо ч мөнхийн улсад жаргаад байгаа юм бол юунд энэ дэлхий дээр эргэн ирж, шинэ бие махбодтой болох ёстой гэж?

Ялангуяа хэрэв махбод сэтгэлийг хорьдог шорон төдий гэж заасан грекчүүдийн зөв юм бол?

Нөгөө талаар итгэдэггүй үхэгсэд шууд л тамд ордог юм бол Ертөнцийн Эзэн тэднийг шүүхийн тулд яагаад үхлээс амилуулах ёстой вэ (Илчлэлт 20:11-13)?



Энэ асуулт өөрийн эрхгүй төрдөг учраас Христитгэлт сүм чуулгануудад үхлээс амилах амиллын тухай бараг заадаггүй байх.

Гэтэл Бичвэрүүдийн дагуу Бүтээгч Эзэн хүч чадлаа хамгаас илүүтэйгээр үзүүлэх явдал нь үхэгсдийг мөнхөд тамлах биш, харин шинэ амьдралд амилуулах явдал юм. Тэр үед Бүтээгч Эзэн хүч чадлынхаа “хэмжээлшгүй сүр жавхланг” үзүүлэх



болно (Эфэс 1:17-23). Гэтэл бүрмөсөн нас бараагүй хүнийг Бүтээгч Эзэн хүртэл дахин амилуулна гэж байхгүй шүү дээ. Хүн үхлээс амилахын тулд эхлээд үхсэн байх ёстой нь жам (1 Коринт 15:36). Сэтгэлийн үхэшгүйн тухай онол сургаал үхлээс амилах амиллыг шаардлагагүй болгоод бүү хэл, боломжгүй болгодог нь дэндүү том асуудал юм. Энэ нь Бүтээгч Эзэний хамгийн агуу их хүч чадлыг үгүйсгэх оролдлого мөн.

5. Энэ бүхэн шууд л бидний итгээд аврагдах сайн мэдээг ойлгох ойлголтонд маань нөлөөлнө. Христ бидний гэмийг авч хаяхын төлөө үхээд оршуулагдсаны дараа үхлээс амилсан нь сайн мэдээний хамгийн үндсэн чухал зүйл мөн (1 Коринт 15:1-4).



Есүс загалмай дээр амин сүнсээ Аавынхаа гарт тушааж амьсгаа хураав. Тэрнээс хойш дахин амилтал нь Есүсийн сэтгэл грек биш еврей “Үхэгсдийн оронд” байсан, өөрөөр хэлбэл оршихоо болив (Үйлс 2:27, Дуулал 16:10). Гурван хоногийн дараа Ертөнцийн Эзэн-Эцэг Есүсийн амин сүнсийг эргээд бие махбодод нь оруулж амилуулан Есүсийг дахин амьд сэтгэл болгосон. Үр дүнд нь Есүс тэр бунханаас алхан гараад, Өөрийгөө дагалдагч нартаа үзүүлж, “Миний гар, Миний хөлийг хараач. Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм” гэв (Лук 24:39).

Үнэн итгэгч хүний итгэх итгэлийн цөм нь Христийн үхэл ба үхлээс амилсан амилал билээ. Үүнд үхэшгүй сэтгэлийн тухай ойлголт багтахгүй.

6. Үхлээс амилах амиллыг дүрсэлдэг үлгэр загвар Библид олон бий. Иона бол тийм үлгэр загвар. “Иона аварга загасны гэдсэнд гурван өдөр, гурван шөнө байсанчлан Хүний Хүү газрын зүрхэнд гурван өдөр, гурван шөнө байх болно” гэж Есүс нэг хэлсэн (Матай 12:40). Загасны гэдэс Ионагийн хувьд булш нь болох гэж байсан. Гэтэл тэр загас Ионаг хуурай газар луу бөөлжин гаргасан нь түүний хувьд үхлээс амилах шиг болов.

Бас нэг удаа Есүс Өөрийгөө газар унаж үхээд, шинэ ургамал ургуулдаг улаан буудайн үртэй зүйрлэжээ. Тийм үр “үхвээс олон үр гаргана” (Иохан 12:24).





Харин үхэгсдээс амилуулагдахдаа Есүс “нойрсогсдын анхны үр жимс” болсон бөгөөд араас нь хамаг хүн төрөлхтөн адилхан маягаар дагах ёстой (1 Коринт 15:20-22). Есүс бол үхлээс амилах амилалтаар манлайлагч Нэгэн болсон учраас тэр. Үхэгсэд дахин амилахыг Паул ч гэсэн, тарьсан үр газраас ургахтай зүйрлэсэн (1 Коринт 15:35-38). Газар таригдсан үг газраас ургах нь үхлээс амилахыг тод дүрслэх үлгэр загвар мөн. Дарс бол үхлээс амилахын бас нэгэн үлгэр загвар. “Үхтлээ” гишгүүлсэн усан үзмийн шүүс газар доорх зооринд ороод тэндээс гарахдаа спирттэй (латин: “сүнстэй”) дарс болсон байдаг. Сэтгэл үхлээр хальж одон өөр биед эсвэл ер бусын нэг газар мөнх орших төсөөлөл нь эдгээр үлгэр загвартай нийцэхгүй. Нөгөө талаар сэтгэлийн үхэшгүйг дүрсэлсэн үлгэр загвар Бичвэрүүдээс олдохгүй.

7. Сэтгэл үхэшгүй мөнх гэдэгт итгэхээр логикийн асуудал олон гарна. Логик буюу учир зүй бол амьдралын үндсэн чанар. Үнэн зүйл хэзээд учир зүйн авцалдаатай байдаг. Тийм учраас Бүтээгч Эзэн Өөрөө логикийн эзэн. Оршин тогтнохын түвшин дээр бодохоор, биегүй сэтгэл яаж амьдарч чадах



вэ? Тамын гал бодитой юм бол биегүй сэтгэлд хэрхэн нөлөөлж чадах вэ? зэрэг асуултууд тавигдана.



Гэхдээ энэ нийтлэлийн хэмжээнд зөвхөн Библийн түвшинд гарах логикийн зөрөлдөөнийг авч үзье. Энэ талаар нэгэн үндсэн ойлголт Христэд итгэдэг хүнд байдаг. Тухайлбал: Бүтээгч Эзэний Үг үнэн бөгөөд тийм учраас бүтнээрээ учир зүйн авцалдаатай байдаг. Сэтгэлийн үхэшгүй нь дэндүү олон Библийн үгтэй ч, үлгэр загвартай ч таардаггүй.

Библийн түүх болгон дотроо ч авцалдаатай байх ёстойн ганц жишээг өгье.

Нас барсан найз Лазараа Есүс үхлээс амилуулсан мөчийг эргэж санана уу (эсвэл түүхийг нь дахин уншина уу: Иохан 11).

Лазар амьсгаа хураахдаа шууд л диваажинд очиж, тэнд үнэн сайхан жаргасан гэж бодъё. Гэвч Есүс дуудахад Лазар гэнэт тэр яруу сайхан газраас суга татагдан, харанхуй өмхий булшинд, зовлонт энэ дэлхийд эргэж ирэх ёстой. Үүнд Лазарын уур хүрээгүй нь гайхалтай биз дээ. Мөн диваажин ямар байсан тухай Лазар ганц ч үг дуугараагүй нь хачирхалтай шүү. Улмаар, хэн ч диваажингийн жаргалын талаар

түүнээс юу ч асуусангүй нь гайхмаар.

Энэ байдлыг хэрхэн тайлбарлах вэ?

“Оккамын сахлын хутга” гэдэг учирзүйн чухал зарчим бий.

Их Эзээн, тавхан минут хүлээгээч дээ!





Логикын энэ зарчмын дагуу “цөөн багажаар хийж болох ажлыг олон багажаар хийх дэмий”, өөрөөр хэлбэл, “хамгийн энгийн тайлбар нь зөв байж таарна”. Байж боломгүй, магадлал багатай тайлбарыг “Оккамын сахлын хутгаар хусч ав”.

Оккамын сахлын хутгын жишээ: Туурайн нижигнээн сонсоход



“Хамгийн энгийн тайлбар нь зөв байж таарна.”

Лазарыг үхлээс амилсны дараах байдал дээр “Оккамын сахлын хутгыг” хэрэгжүүлэхэд, хамгийн энгийн тайлбар бол энэ: Лазар үхээд, булшин дотроо ямар ч ухаан мэдрэлгүй хэвтэж байсан бөгөөд сая л нойрноос сэрсэн шиг босож, булш бунхнаасаа гарсныг нь бүгд мэдсэн. Лазар өөрөө нүд аньсан тэр мөчөөс эхлэн, Есүсийн дуунд сэрээгдсэн агшин хүртэл юу болсон тухай юу ч мэдсэнгүй.

Энэ тайлбар Бичвэрүүдийн олон үгтэй нийцэх бөгөөд Лазар ба эргэн тойронд нь буй хүмүүсийн байгаа байдлыг хамгийн сайнаар тайлбарлаж чадна. Тийм учраас энэ нь зөв тайлбар нь болж таарна. Харин “сэтгэл нь үхээгүй, диваажин явсан” гэсэн үндэслэл муутай таамаглалыг “хусч авах” нь зөв.



8. “Оккамын сахал” зэрэг учир зүйн зарчмыг ашиглахын тулд Бичвэрүүдийн үгийг аль болохоор шууд утгаар, өөрөөр хэлбэл, өөр ном зохиолыг ойлгож авдаг тэр л аргаар хүлээж авах хэрэгтэй. Гэтэл Библийг тайлбарлах олон багш Бичвэрүүдийн үгийг байгаагаар нь биш, “сүнслэгжүүлсэн” утгаар тайлбарладаг. Энэ нь Библийн үгийг дураараа тайлбарлахыг хэлнэ. Үр дүнд нь үхэл ба үхлийн дараах амьдралын тухай янз бүрийн зөрүү тайлбар, сургаал Христитгэлд байдаг болсон. Үүнээс болж энгийн итгэгч хүн өөрийгөө Ертөнцийн Эзэний үгийг ойлгож чадахгүй гэсэн урам хугалам сэтгэгдэлтэй үлддэг. Эсвэл итгэгчид өөрсдөө Библийн үгийг сүнслэгжүүлэхийг сурч, дураараа тайлбарлахад хүрнэ.



Дээрх бүхнээс дүгнэхэд үхэшгүй мөнх сэтгэлийн тухай сургаалд итгэх нь үнэнг ухаарах чадвар ч, итгэх итгэлд ч хор нөлөө үзүүлнэ. Бичвэрүүдийн үндсэн сургаалыг хүлээж аваагүйгээс болж, дээр нь үндэслэсэн бусад сургаалыг ч зөв ойлгохгүйд хүрнэ. Хүн зөвхөн сонссон, мэдсэн зүйлдээ итгэж болох нь жам (Ром 10:17). Үхлийн тухай Их Эзэний Бичвэрүүдээр дамжуулсан үгийг мэдэлдээ аваагүй хүн тэрэнд итгэж чадахгүй нь мэдээж.



Гэвч үндсэн чухал үнэнд итгэдэггүй байх нь Бүтээгч Эзэний бусад Үгэнд бүү хэл, Түүнд Өөрт нь итгэхэд саад болж мэдэхийг бид дээр харсан. Энэ эмгэнэлт үр дагавар нь тус онолын ёрын муу эх үүсвэрийг мөн заана (Матай 7:20).



Ингээд асуулт дахиад л танд ирлээ: Та Бүтээгч Эзэний үхлийн тухай хэлсэн Үгэнд шууд утгаар нь хүлээн авч итгэх үү?

Паулын сайн тэмцэл

“Үхлээр хүний сэтгэл үхдээгүй, харин ч шорон мэт хорьж байсан биенээсээ чөлөөлөгддөг” гэж үздэг

Афин хотын грек философичдоод Паул, үхэгсдийг биеэрээ үхлээс амилах тухай ярьсан. Энэ нь бүгдэд сонин хачин санагдсан бөгөөд зарим нь Паулын үгийг доогложээ (Үйлс 17:18-32).



Паул байнга л хүн төрөлхтөний гүн ухаан ба уламжлалын эсрэг тэмцэхэд хүрдэг байсан. Энэ тэмцэл нь Афин хотынхных шиг шашинлаг домгонд үндэслэсэн үзэл бодлын эсрэг байхаас гадна, бусад үндэстнүүдээс гаралтай итгэгчдийг иудейжүүлэх санаа бодлын эсрэг ч байв. Үүгээр ч зогсохгүй,




хуучин шашныхаа ойлголт руу буцдаг итгэгч хүмүүсээ ч засч залруулах шаардлага Паулд олонтаа гарсан.

Тимотод Паул бичихдээ: “Олиггүй хоосон ярианаас зайлсхий. Учир нь тийм зүйлс хүмүүсийг итгэл сүсэггүй байдал руу улам хөтөлдөг юм. Тэдний үг хавдар тархах мэт бөгөөд дунд нь Хуменай, Филет нар байна. Тэд

үнэнээс төөрч,
амилал нь аль хэдийн болсон хэмээн заримынх нь итгэлийг бусниулж байна.
(...)

Цаг нь ирэхэд хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ



дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсдөдөө цуглуулах бөгөөд чих нь үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно. Харин чи бүх юманд саруул ухаантай бай, хэцүүг тэвч, сайн мэдээг тунхаглагч ажлыг хий, үйлчлэлээ гүйцэтгэ” (2 Тимот 2:16-18; 4:3-5).

Тухайн үед садукайчууд, эссенчүүд, гностикууд зэрэг олон шашинлаг урсгалын хувьд “үхлээс амилах амилал” нь зөвхөн зүйрлэсэн (сүнслэгжүүлсэн) утга бүхий ухагдахуун байлаа.



“Амилал нь аль хэдийн болсон” гэж заадаг Хуменай, Филет нар нарийвчлан яг юу заадаг байсныг бид өнөөдөр мэдэхгүй. Гэтэл “үхлээс амилах нь ирээдүйд хүн биеэрээ булшнаас босож амилахыг хэлээгүй, харин сэтгэл сүнсээрээ гэм нүглийн үхлээс амилж, үхлийн хойно биегүй тэр сэтгэл сүнсээрээ тэнгэрийн улсад явахыг хэлнэ” гэж заадаг байсан нь магадлал ихтэй. Өөрөөр хэлбэл, “хүний сэтгэл биегүй болсон ч гэсэн цаашид амьдарна” гэдэг бодит байдлыг үл хайхарсан нөгөө санаа.

Үхэгсэд дахин амилна гэсэн Бичвэрүүдийн сургаал нь үнэн сайн мэдээг ойлгоход хүртэл үндсэн чухал юм. Учир нь сайн мэдээний үндэс бол Христийн



үхэл ба дахин амилал билээ. Тийм ч учраас Паул энэ талаарх буруу сургаалыг дэндүү аюултайд тооцсон. Хуменай лав “цэвэр зүрхнээс гарах хайр, сайн мөс чанар болон чин үнэнч итгэл”-ээс “няцаж, дэмий ярианд

хэлбийн орсон” итгэгч байв. “Юу хэлж, юуны талаар итгэлтэйгээр баталж байгаагаа ч ойлгодоггүй” тэрээр итгэлээ сахиагүйгээс болж “итгэл нь сүйрсэн хөлөг онгоц мэт болжээ” (1 Тимот 1:6-7, 19-20).



Харин та яах вэ? Үнэнээс төөрсөн хүмүүсийн үгэнд итгэх үү? Ертөнцийн Их Эзэний үгэнд найдах уу?



*“Аврал үгүй хүмүүний үр болох
Ахлагч ноёдод бүү найдвар тавь.
Амьсгал хурааж шороондоо тэр буцна.
Аяа, тэр л өдөр бодол төлөвлөгөө нь устана.
Иаковын Бурхан тусламж нь болдог
Бурхан ИАВЭдаа найддаг хүн
юутай сайшаалтай!
Тэнгэр газар, тэнгис далайг
Тэдгээрт оршигч бүхэнтэй нь бүтээсэн Тэрбээр
Үнэнч сэтгэлээ үүрд мөнх хадгалдаг билээ.”
(Дуулал 146:4-6) □*

“Гэхдээ үхээгүй гэдэг Мосе, Елиа хоёр яах вэ? Тэд Есүсийн дүр хувирахад Түүнтэй ярилцах гэж нөгөө уулан дээр ирсэн биз дээ? Бас Есүс загалмай дээр үхэх гэж байхдаа тэр л өдөр диваажин очих тухай ярьсан биш үү?” зэрэг асуулт олон хүнд байгаа биз ээ. Үхлийн тухай илчилсэн Бичвэрүүдийн сургаалтай зөрчилдөх мэт эдгээр тохиолдлыг дараагийн нийтлэлдээ авч үзэх болно.



Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Bacchiocchi, S. (1998). Immortality or Resurrection?

<https://www.truthaccordingtoscripture.com/documents/death/immortality-or-resurrection/immortality-or-resurrection-ch1.php>

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Hanson, J.W. (1899). *Universalism: The prevailing doctrine of the Christian Church during its first five hundred years (and showing the influence of Greek mythology and pagan philosophy on Christian doctrine)*. Boston and Chicago: Universalist publishing house.

<https://tentmaker.org/books/Prevailing.html#271>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Stott, J.R.W. and Edwards, D. (1988). *Essentials, A Liberal-Evangelical Dialogue*. London: InterVarsity Press.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons)*. www.blueletterbible.org